шаардлага, 1,478.0 сая төгрөгийн 86 зөвлөмж өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

Нийцлийн аудитын асуудлын түвшинд нийт 32.6 сая төгрөгийн 17 зөрчил илэрснээс 12.8 сая төгрөгийн 4 албан шаардлага, 19.8 сая төгрөгийн 13 зөвлөмж өгсөн байна

3.2 Орхон аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит.

Орхон аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах өөрчлөлтүүд орж, залруулга хийлээ. Үүнд:

- Жаргалант ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн эзэмшлийн газрын эрхийн 4.5 сая төгрөгийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бус газраар бүртгэж тайлагнасан,
- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд биет хөрөнгө, хуримтлагдсан үр дүнг 120.2 сая төгрөгөөр илүү буюу нэгтгэсэн үр дүнгийн тайланд элэгдлийн зардалтай холбоотойгоор бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, үйл ажиллагааны бус зардлыг тус дүнгээр дутуу илэрхийлсэн,

Аудитаар нийт 2,660.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, ажлаас чөлөөлөх сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 2,659.2 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 5,701.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 6,198.2 сая төгрөгөөс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн.

3.2.1 Төлбөрийн акт

Аймгийн Засаг даргын А/441 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргад олгосон 4.5 сая төгрөгийн, А/996 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын тамгын газрын ахлах нягтлан бодогч, няравт нарт олгосон 11.0 сая төгрөгийн дэмжлэгээс 1.6 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосонд акт тогтоов.

3.2.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага

"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-н 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь аудитын хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарласан тул "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" тул гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлүүлэх хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жижиг дунд үйлдвэр болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Хаан банканд байршиж буй 300.0 сая төгрөгийг санхүүгийн нэгтгэсэн тайланд 2025 оны 12 дугаар

сарын 31-ний өдрийн байдлаар Төрийн сангийн арилжааны банкин дахь үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35.3-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны А122/А-172 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр арилжааны банканд шинээр данс нээхгүй байж, данс эзэмшигч нь арилжааны банк бол санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгөөр бүртгэлгүй, авлагын дансанд бүртгэж тайлагнах.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын Цагаанчулуун багийн нутагт баригдсан 315 айлын орон сууцны өмчлөгч, түрээслэгч иргэдийн Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2025 онд төлсөн эргэн төлөлтөөс 560.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд шилжүүлж, 2,247.2 сая төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 31-нд ерөнхий орлогын дансанд /910/ төвлөрүүлж, орон нутгийн төсвийн татварын бус орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд тооцсон, 1.8 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна. Монгол Улсын Хөгжлийн банкттай аймгийн Засаг даргын байгуулсан Цагаанчулуут багийн нутагт баригдсан 315 айлын орон сууц, 42 грашийг "Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-ний хугацаа 2024 оны эцсээр дууссан байна. Зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлж барагдуулаагүй, иргэдээс төлсөн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь зээлийн хугацаа хэтэрсний алданги, хүүгийн хүүгийн зардлыг нэмэгдүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 33.2-д "Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална", 33.2.8-д "төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээний хугацаа хэтрүүлсний алданги, хүүгийн зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1104 дугаар захирамжийн хавсралтаар аймгийн ЗДТГ-аас 2023, 2024 онд худалдан авсан ашиглалтын хугацаа дуусаагүй, 31.4 сая төгрөгийн балансын үнэтэй, 10.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 20.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг акталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 73 дугаар зүйлийн 4-д "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02/18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.2-д "Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд аймгийн Засаг даргын шийдвэрээр данснаас хасна", 7.2.2-д "Ашиглалтын хугацаа дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд", 8.4.3-д "Байгалын болон давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюул, осолд орсон бол хохирол тогтоосон тухайн үеийн акт", 10.3-д "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын хугацаа дуусаагүй акталсан 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 2026 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд буцаан бүртгэх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах" ОРАБӨСЗДТГ/20250102109 дугаартай 2,550.0 сая төгрөгийн гэрээний дагуу нийлүүлсэн, хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, бараа хүлээн авсан акт, Орон нутгийн өмчийн газрын даргын албан бичгээр баталгаажиж, Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркард хүлээн авч, бүртгэсэн хөрөнгөнөөс 8.7 сая төгрөгийн үнэ бүхий DTF машин дутсан нь аймгийн Засаг даргын 2026 оны А/67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн "Эрдэнэт шинжлэх, технологийн парк ОНӨААТҮГ"-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй эд хөрөнгийг тоолж хүлээн авах тооллогоор илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4-д "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дутсан хөрөнгийг биетээр нь бүрэн хүлээж авч, бараа хүлээж авах ажлын комисст ажиллаж буй албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх.

5. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орхон аймгаас санхүүжүүлж Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас иргэдэд олгосон итгэлийн зээлийн эргэн төлөлтөөс 2025.12.31-ний өдрийн байдлаар тус парк нь 81.1 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д "1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй", 1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 1.3-д "үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтийг судалж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд бүрэн шийдвэрлэх.

6. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 02/6811 тоот албан бичгээр аймаг, нийслэл дэх Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланг тухайн орон нутгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн тайлагнах талаар мэдээллийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллага тус бүрээр бус нэг эрхээр нэгтгэн шивдэг, аж ахуй нэгж байгууллагын и-баланс системд санхүүгийн тайлангаа шивээгүй эсхүл алдаатай шивж баталгаажуулж байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2025 санхүүгийн тайлангийн аудитыг түүвэрт хамруулан гүйцэтгэхэд 61.9 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 132.9 сая төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж, Үйлсбадрах ӨЭМТ-н дарга, нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 65.1-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 65.1.2-д "орон нутаг дахь төсвийн байгууллага, төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.5-д "Энэ хуулийн 10.3-т зааснаас бусад болон энэ хуулийн 10.4-т заасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэгтгэлд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага жилийн санхүүгийн тайлангаа дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланг и-баланс болон санхүүгийн нэгтгэсэн тайланд /тус тусдаа эрх олгох асуудал/ шивж илгээж буй мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд чанартай хяналт хэрэгжүүлж, санхүүгийн ажилтнуудын хариуцлагыг нэмэгдүүлж, төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг хугацаанд хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

7. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны төсвийн ерөнхийлөн захирагчийн хэсэгт аймгийн Засаг даргын 18 захирамжийг /78, 105, 148, 247, 258, 295, 355, 431, 441, 575, 726, 728, 821, 825, 900, 978, 1101, 1104/ байршуулаагүй, 250 захирамжийг хугацаа хоцроож

мэдээлсэн, мөн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй мэдээлж, мэдээллийг ил тод байдлыг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл – Төсвийн ерөнхийлөн захирагч

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн эзэмшлийн газрын эрхийн 4.5 сая төгрөгийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бус газраар бүртгэж тайлагнасан байна.	1	120.2			1	120.2	1	120.2				
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд биет хөрөнгө, хуримтлагдсан үр дүнг 120.2 сая төгрөгөөр илүү буюу нэгтгэсэн үр дүнгийн тайланд элэгдлийн зардалтай холбоотойгоор бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, үйл ажиллагааны бус зардлыг тус дүнгээр дутуу илэрхийлсэн байна.	1	4.5			1	4.5	1	4.5				
ДҮН	2	124.7			2	124.7	2	124.7				

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Засаг дарга	2	124.7			2	124.7	2	124.7				
Орхон аймгийн Баян-Өндөр сумын засаг даргын тамгын газар	1	297.1			1	297.1	1	297.1				
Орхон аймгийн худалдан авах ажиллагааны газар	1	0.7			1	0.7	1	0.7				
Мөнх сүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	1	45.2	1	45.2			1	45.2				
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	1	55.5	1	55.5			1	55.5				
Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв	2	30.0			2	30.0	2	30.0				
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	8.2			1	8.2	1	8.2				
Орхон аймгийн хот байгуулалт, барилга захиалагчийн алба	2	280.0			2	280.0	2	280.0				
Орхон аймгийн хот тохижуулах газар	1	0.0	1	0.0			1	0.0				
Орхон аймгийн цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	4	513.6	1	199.3	3	314.3	4	513.6				
Орхон аймгийн орон нутгийн өмчийн газар	1	803.0			1	803.0	1	803.0				
Баян-Өндөр сумын засаг Дарга	1	168.4			1	168.4	1	168.4				
Орхон аймгийн Жаргалант сумын засаг даргын тамгын газар	1	68.3			1	68.3	1	68.3				
Орхон аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар	1	3.7			1	3.7	1	3.7				
ДҮН	20	2,398.3	4	300.0	16	2,098.3	20	2,398.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл – Төсвийн ерөнхийлөн захирагч

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Засаг даргын А/441 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргад олгосон 4,500.0 мянган төгрөгийн, А/996 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын тамгын газрын ахлах нягтлан бодогч, няравт нарт олгосон 11,000.0 мянган төгрөгийн дэмжлэгээс 1,550.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.	1	1.6	1	1.6									
"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-н 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь аудитын хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарласан тул "Дүгнэлт өгөхөөс татгалзсан".	1	0.0								1	1	0.0	
Жижиг дунд үйлдвэр болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Хаан банканд байршиж буй 300,000.0 мянган төгрөгийг санхүүгийн нэгтгэсэн тайланд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Төрийн сангийн арилжааны банканд дахь үлдэгдлээр тайлагнасан байна.	1	300.0					1	300.0					

Орхон аймгаас санхүүжүүлж Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас иргэдэд олгосон итгэлийн зээлийн эргэн төлөлтөөс 2025.12.31-ний өдрийн байдлаар Эрдэнэт ШУТПарк нь 81,130.3 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	1	81.1					1	81.1				
"Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах" ОРАБӨСЗДТГ/20250102109 дугаартай 2,550,000.0 мянган төгрөгийн гэрээний дагуу нийлүүлсэн, хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, бараа хүлээн авсан акт, Орон нутгийн өмчийн газрын даргын албан бичгээр баталгаажиж, Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парсад хүлээн авч, бүртгэсэн хөрөнгөнөөс 8,690.0 мянган төгрөгийн үнэ бүхий DTF машин дутсан нь аймгийн Засаг даргын 2026 оны А/67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн "Эрдэнэт шинжлэх, технологийн парк ОНӨААТҮГ"-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй эд хөрөнгийг тоолж хүлээн авах тооллогоор илэрсэн байна.	1	8.7					1	8.7				
Аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1104 дугаар захирамжийн хавсралтаар аймгийн ЗДТГ-аас 2023, 2024 онд худалдан авсан ашиглалтын хугацаа дуусаагүй, 31,439.8 мянган төгрөгийн балансын үнэтэй, 10,972.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 20,467.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг ацталсан байна.	1	20.5					1	20.5				

<p>Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын Цагаанчулуун багийн нутагт баригдсан 315 айлын орон сууцны өмчлөгч, түрээслэгч иргэдийн Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2025 онд төлсөн эргэн төлөлтөөс 560,646.9 мянган төгрөгийг Хөгжлийн банканд шилжүүлж, 2,247,170.2 мянган төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 31-нд ерөнхий орлогын дансанд /910/ төвлөрүүлж орон нутгийн төсвийн татварын бус орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд тооцсон, 1,790.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна. Монгол Улсын Хөгжлийн банкт аймгийн Засаг даргын байгуулсан Цагаанчулуут багийн нутагт баригдсан 315 айлын орон сууц, 42 грашийг "Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-ний хугацаа 2024 оны эцсээр дууссан байна. Зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлж барагдуулаагүй, иргэдээс төлсөн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь зээлийн хугацаа хэтэрсний алданги, хүүгийн хүүгийн зардлыг нэмэгдүүлж байна.</p>	1	2,249.0					1	2,249.0						
<p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны төсвийн ерөнхийлөн захирагчийн хэсэгт аймгийн Засаг даргын 18 захирамжийг /78, 105, 148, 247, 258, 295, 355, 431, 441, 575, 726, 728, 821, 825, 900, 978, 1101, 1104/ байршуулаагүй, 250 захирамжийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.</p>	1	0.0					1	0.0						

<p>Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 02/6811 тоот албан бичгээр аймаг, нийслэл дэх Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланг тухайн орон нутгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн тайлагнах талаар мэдээллийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллага тус бүрээр бус нэг эрхээр нэгтгэн шивдэг, аж ахуй нэгж байгууллагын и-баланс системд санхүүгийн тайлангаа шивээгүй эхсүл алдаатай шивж баталгаажуулж байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2025 санхүүгийн тайлангийн аудитыг түүвэрт хамруулан гүйцэтгэхэд 61,879.5 мянган төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 132,917.2 мянган төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж, Үйлсбадрах ӨЭМТ-н дарга, нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.</p>	1	0.0					1	0.0						
Дүн	9	2,660.8	1	1.6	0	0.0	7	2,659.2	1	1	0.0			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	7	118.6	4	2.8	2	115.9	1	0.0	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ	5	47.8	1	2.0	2	44.3	2	1.5	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг дарга	8	2,660.8	1	1.6	0	0.0	6	2,659.2	1	1	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ	11	247.1	5	39.7	1	193.1	5	14.3	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ	4	6.0	2	2.2	0	0.0	2	3.9	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн худалдан авах ажиллагааны газар	3	1.4	1	0.0	0	0.0	2	1.4	0	0	0	0.0	0	0.0
Мөнх сүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	6	37.1	3	16.9	0	0.0	3	20.3	0	0	0	0.0	0	0.0
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	7	18.4	3	11.4	1	0.0	3	7.1	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын ОНХСан	3	4.6	1	1.8	1	2.8	1	0.0	0	0	0	0.0	0	0.0
Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв	5	3.7	3	1.2	0	0.0	2	2.5	0	0	0	0.0	0	0.0
Энхжих мандариваа өрхийн эрүүл мэндийн төв	5	15.8	2	0.3	0	0.0	3	15.5	0	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Теле камерын хяналтын дэд төв	2	7.1	0	0.0	0	0.0	2	7.1	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн нийтлэг үйлчилгээний алба	7	41.6	1	0.6	2	24.8	4	16.2	0	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт хотын захирагчийн алба	3	27.9	0	0.0	1	8.2	2	19.7	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн хот байгуулалт, барилга захиалагчийн алба ААТҮГ	8	61.3	5	14.2	2	24.8	1	22.3	0	0	0	0.0	0	0.0
Мэнд цэцэн өрхийн эрүүл мэндийн төв	5	49.0	3	14.4	0	0.0	2	34.7	0	0	0	0.0	0	0.0
Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв	3	12.2	1	0.5	0	0.0	2	11.6	0	0	0	0.0	0	0.0
Орон нутгийн хөрөнгө оруулалт	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	38.0	0	0.0	0	0.0	1	38.0	0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн хот тохижуулах газар	11	660.6	6	13.1	4	647.5	1	0.0	0	0	0	0.0	0	0.0
Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв	6	25.8	2	17.2	1	0.0	2	8.6	1	2	0	0.0	0	0.0

Жаргалант сумын Засаг дарга	4	174.1	0	0.0	0	0.0	4	174.1	0	0	0.0	0	0.0
Анхны оч өрхийн эрүүл мэндийн төв	4	32.7	0	0.0	0	0.0	4	32.7	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Автозамын сан	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр	1	125.4	0	0.0	0	0.0	1	125.4	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн гэр бүлийн ордон ААТҮГ	4	32.2	1	0.5	2	31.7	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	4	59.0	1	0.4	1	16.8	2	41.8	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн аялал жуулчлал амралтын их шүтээн цогцолбор	3	0.2	1	0.2	0	0.0	2	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн сум дундын ойн анги	5	5.2	1	0.1	1	1.6	3	3.5	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн засаг даргын тамгын газар	6	70.3	1	1.2	4	69.1	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн орон нутгийн өмчийн газар	2	1.0	1	1.0	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	10.0	0	0.0	2	10.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	3	7.9	1	0.8	1	6.0	1	1.1	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сан	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Баян-Өндөр сумын Засаг дарга	6	152.6	0	0.0	0	0.0	6	152.6	0	0	0.0	0	0.0
Халамж сан / орон нутгийн төсөв/	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Эрдэнэт сан	1	143.1	0	0.0	0	0.0	1	143.1	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-өндөр сумын ОНХСан	3	631.3	0	0.0	2	86.1	1	545.2	0	0	0.0	0	0.0
"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ	5	1.5	3	1.5	0	0.0	2	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын засаг даргын тамгын газар	10	67.6	3	6.9	2	55.1	5	5.6	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар	2	4.2	0	0.0	1	4.2	1	0.0	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК	6	65.9	0	0.0	2	37.6	4	28.3	0	0	0.0	0	0.0
Дүн	186	5,669.1	57	152.3	35	1,379.5	92	4,137.2	2	3	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0.0					1	0.0
Орхон аймгийн хот байгуулалт, барилга захиалагчийн алба	1	19.8					1	19.8
Орхон аймгийн нийтлэг үйлчилгээний алба	1	0.0					1	0.0
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	0.0					1	0.0
Орхон аймгийн гэр бүлийн ордон ААТҮГ	1	0.0			1	0.0		
Жаргалант сумын Засаг дарга	1	0.0					1	0.0
Орхон аймгийн цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	1	0.0			1	0.0		
Орхон аймгийн аялал жуулчлал амралтын их шүтээн цогцолбор	1	0.0			1	0.0		
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сан	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	0.0					1	0.0
Баян-Өндөр сумын Засаг дарга	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын засаг даргын тамгын газар	1	0.0					1	0.0
"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Засаг дарга	1	0.0					1	0.0
Дүн	15	19.8			3	0.0	12	19.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орхон аймгийн хот тохижуулах газар	1	12.8			1	12.8		
Орхон аймгийн Баян-өндөр сумын хоршоо хөгжүүлэх сан	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Баян-өндөр сумын хоршоо хөгжүүлэх сан	1	0.0					1	0.0
Дүн	3	12.8	0	0.0	1	12.8	2	0.0
Нийт дүн	18	32.6	0	0.0	4	12.8	14	19.8